



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/123

Ховд

**Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн
төлөвлөгөөг үнэлэх үнэлгээний баг байгуулах тухай**

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн жинхэнэ албан хаагчдын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Багийн ахлагч:

Б.Ганболд - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Ч. Багдал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Ганхуяг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

Б.Даваадорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Д.Ариунбилэг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Нарийн бичгийн

дарга: Т.Мандухай - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2.

2. Төрийн албан хаагчдын бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 18-ны дотор журмын дагуу үнэлж, баримт материалыг бүрдүүлэн баталгаажуулж, үйл ажиллагааны үр дүнг илтгэн, авах арга хэмжээний зөвлөмж боловсруулан ажиллахыг үнэлгээний багийн нийт гишүүдэд даалгасугай.

3. Үнэлгээний багийг удирдлагаар ханган, хууль тогтоомжид заасан хугацаанд үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, хариуцлагатай ажиллахыг багийн ахлагч /Б.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД